ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2018 оны 05 дугаар сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт

1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2018 оны 05 сард 563 эх амаржиж, 565 хүүхэд шинээр мэндэлжээ. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 45(8.7%)-оор, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 42(8.0%)-өөр, 160 хүн нас барсан нь 13(8.8%)-аар тус тус өссөн байна.

Хүн амын цэвэр өсөлт 405 болж өмнөх оны мөн үеэс 29(7.7%)-ээр өсчээ. 1000 хүнд ногдох төрөлт 8.4, нас баралт 2.4 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.3 пунктээр буурч, нас баралт 0.1 пунктээр өссөн байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2015-2018 оны 05 сард



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд нялхсын эндэгдэл 8 байгаа нь өмнөх оны мөн үеэс 3-аар илүү байна.

1.2 Эрүүл мэнд

2018 оны 05 сарын байдлаар 154.0 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар, 7.6 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар тус тус өсч, 4.6 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 6.1 хувиар буурчээ.

2018 оны 05 сард 665 эх жирэмсний хяналтанд орсны 86.5 хувь буюу 575 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.9 хувиар буурсан байна.

.

Түргэн тусламжийн дуудлага 8.7 мянган удаа гарсны 1.5 мянга буюу 17.2 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 6.1 хувиар, алсын дуудлага 7.1 хувиар тус тус өссөн байна.

Он гарсаар ослын улмаас 1299 хүн бэртэж, 32 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 167(14.8%)-аар нэмэгдэж, нас барсан хүний тоо 4 (%)-өөр буюу 11.1 хувиар буурсан байна.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2018 оны 05 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд цусны эргэлтийн тогтолцооны өвчин 28.9 хувь, хавдар 22.7 хувь, хоол шингээх эрхтний өвчин 8.6 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 8.6 хувь, осол гэмтэл, хордлого гадны шалтгаант нас баралт 18.8 хувь, бусад төрлийн өвчин 12.0 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 306 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 141(31.5%)-ээр буурчээ. Халдварт өвчний тохиолдол буурахад сүрьеэ 2.4 хувь, трихомониаз 20.0 хувь, тэмбүү 24.6 хувь, вирус гепатит 66.7 хувиар, бусад төрлийн өвчин 63.1 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2018 оны 05 сарын эцэст 860 болсны 833 (96.8%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 27 (3.2%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 790 (52.1 %) хүнээр буурч, өмнөх сараас 119(16.1%) хүнээр өссөн байна. Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 408 (47.4%) нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 445 (51.7%) нь Сайншанд суманд, 138 (16.1%) нь Замын-Үүд суманд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 59.9 хувь нь бүрэн дунд, 19.5 хувь нь дээд, 6.4 хувь нь техник болон мэргэжлийн, 6.0 хувь нь бүрэн бус дунд, 5.0 хувь нь тусгай дунд, 0.7 хувь нь бага, 2.3 хувь нь боловсролгүй, 0.1 хувь нь магистр/докторын боловсролтой иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2018 оны 05-р сард



Хөдөлмөрийн хэлтэст 2018 оны 5-р сард 1074 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 133 иргэн ажилд зуучлагдан орж, 98 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна

Хөдөлмөрийн хэлтэст ирсэн 204 ажлын байрны 19(9,3%) нь үйлчилгээний, 109(53.4%) нь уул уурхайн олборлолтын салбарын захиалга байна. Ажил хайгч 133 иргэн хөдөлмөрийн байгууллагаар дамжуулан ажилд зуучлуулан орсны 60 (45.1%) нь эмэгтэйчүүд байна

Зураг. Бүртгэлгүй ажилгүй иргэд сумаар

Зураг. Шинээр ажлын байранд орсон салбараар

1.4 Нийгмийн даатгал, халамж

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 05 сард 13009.5 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2148.5(19.8%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 05 сард өмнөх оны мөн үеэс 2148.5 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 1587.2(24.1%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сан 164.7(24.4%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 179.8(24.1%) сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2018 оны 05 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 17953.0 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 2327.2 (14.9%) сая төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 13162.5(73.3%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 2699.7(15.0%) сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 1041.4(5.8%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 729.6(4.1%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 319.8(1.8%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын зарлага, сая төг



Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээгээр нийгмийн халамжийн сангаас 2018 оны эхний 05 сард нийгмийн халамжийн сангаас 19940 иргэнд 3339.1 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 4071 (25.7%)-өөр, олгосон тэтгэвэр тэтгэмж 882.1 (35.9%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Халамжийн тэтгэвэр, тэтгэмж өсөхөд насны хишиг, цалинтай ээж хөтөлбөрт 5718(28.7%) иргэнд 885.5(26.5%) сая төгрөгийн тэтгэмж олгосон нь нөлөөлсөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2018 онд 1306 хүн хамрагдсан нь өмнөх оноос 31 (2.4%)-ээр, олгосон тэтгэвэрийн хэмжээ 370.1 (65.6 дахин) сая төгрөгөөр нэмэгджээ. Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжид 1020 иргэнд 316.2 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 893 иргэнд 226.7 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХуульд 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 6135 иргэнд хамруулж 296.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Нийгмийн бусад халамжийн шаардлагатай иргэнд үзүүлэх тусламжийг 10586 иргэнд 1565.2 сая төргөг олгосон байна.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /мян төг/



1.5 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр оны эхний 05 сарын байдлаар 251 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 48 хүн гэмтэж, 10 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 37(9.1%)-оор, нас барсан хүний тоо 3(23.1%)-аар, гэмтсэн хүний тоо 45(48.4%) -аар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хүний амины гэмт хэрэг 1 (10.0%)-ээр, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 8 (12.7%)-аар, мал хулгайлах гэмт хэрэг 4(16.0%)-оор, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчсөн гэмт хэрэг 4 (14.8%)-өөр, бусад гэмт хэрэг 1 (50.0%)-аар буурч, авилгын гэмт хэрэг, цэргийн албаны эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 109(43.4%) хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 55(21.9%) хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 23 (9.2%) хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчсөн гэмт хэрэг, 18(7.2%) хувийг улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэргүүд эзэлж байна. Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 25 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 64(71.9%) -өөр буурсан байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Айраг, Өргөн, Сайхандулаан, Эрдэнэ, Сайншанд сумдад буурч, Хатанбулаг суманд өмнө онтой адил, бусад сумдад гэмт хэргийн тоо нэмэгдсэн байна.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 318.9 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 777.4 (70.9) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 230.5 (72.2%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 67 (27.2%) нь гэр сууцандаа, 35(13.4%) нь гудамж олон нийтийн газарт, 25(32.2%) нь согтуугаар, 29 (18.1%) хувийг эмэгтэй хүн, хүүхэд оролцон, 13(9.4%) бүлэглэн, 92(29.7%) нь шөнийн цагаар /22.00-06.00 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 407 хүн эрүүлжүүлэгдэж, 89 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 05 сард



Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт

2.1 Мөнгө, зээл

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын кассын орлого 597.9 тэрбум төгрөг болж өмнөх оноос 142.1(31.2%) тэрбум төгрөгөөр, цэвэр зарлага 617.3 тэрбум төгрөг болж 179.2(40.9%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2017- 2018 он, мян.хүн



Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2017-2018 он, сая.төг



Иргэдийн мөнгөн хадгаламж 89.7 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1305.0 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 1315.6 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж эзэмшигчийн тоо 2.1 (3.2%) мянган хүнээр, хадгаламжийн үлдэгдэл 22.5 (32.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 05 дугаар сарын эцэст 2240.9 сая төгрөг болж, өмнөх сараас 224.3(9.1%) сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 293.1 (11.6%) сая төгрөгөөр тус тус буурсан байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.0 хувийг эзэлж, өмнөх сараас 0.1 пунктээр, өмнөх оны мөн үеэс 9.6 пунктээр буурчээ.

Чанаргүй зээл 05 дугаар сарын эцэст 8652.1 сая төгрөг болж өмнөх сараас 180.7(2.1%) сая төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 147.1 (1.7%) сая төгрөгөөр буурсан. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.0 пунктээр буурсан байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2018.05 сард



Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2018.05 сард



2.2 Орон нутгийн төсөв

2018 оны 05 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 11464.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 101.4 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 43.3 хувиар өссөн байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 72.0 хувийг татварын, 28.0 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2018 оны 05-р сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 2046.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 109.8 (5.7%) сая.төг-өөр нэмэгдэж, тухайн оны төлөвлөгөөнөөс 697.3 (51.7%) сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.

2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2018 оны 05 дугаар сард өмнөх сараас 0.4 хувиар, өмнөх оны мөн үеэс 3.0 хувиар тус тус өсчээ.

Ерөнхий индекс өмнөх сараас 0.4 хувиар өсөхөд: хүнсний бараа, ундаа усны бүлэг 1,2 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодисын бүлэг, 0.4 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 0.9 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээны бүлэг 0.7 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 1.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 05 дүгээр сарын өөрчлөлт, өмнөх сартай харьцуулсанаар (өмнөх сар=100)

Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 05 дугаар сарын өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт

3.1 Хөдөө аж ахуй

Оны эхний 05 сарын байдлаар төллөвөл зохих эх малын 64.9 хувь буюу 540.0 мянган толгой мал төллөж, төл бойжилт 97.9 хувьтай байна. Өмнөх оны мөн үеийнхээс төллөсөн хээлтэгч 31.3 (6.0%) мянган толгойгоор, төл бойжилт 21.7 (4.1%) мянган толгойгоор илүү юм.

Эхний 05-н сарын байдлаар 6940 том мал хорогдож өмнө оны мөн үеэс хорогдол 5.8 (6.2 дахин) мянган толгойгоор нэмэгдсэн байна.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн судалгаагаар Сайншанд суманд 05-р сард ноолуурын дундаж үнэ 95.0 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеэс 45.0 (90.0%) мянган төг-өөр өссөн байна. Харин тэмээний шир 5.0 мянган төгрөг, хонины арьс 1.5 мянган төгрөг, үхрийн шир 10.0 мянган төг-ийн ханштай байна. Сумдад эр хонь 100.0-180.0 мян.төг, эр ямаа 70.0-150.0 мян.төг-өөр худалдаалагдаж байна.

3.2 Аж үйлдвэр

Оны эхний 05 сард аж үйлдвэрийн салбарт 79524,4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 112477.0 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2.3 дахин, борлуулалт 60.7 хувиар тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 4.7 хувийг төрийн, 95.3 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 4.7 хувь, компани 95.0 хувь, өрхийн аж ахуй 0.3 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулвал дулаан 4.0 мян.ккал-аар, сувагжуулалт 29.3 мян.м3-ээр, нарийн боов 9.7 тонноор, бялуу 0.3 тонноор нүүрс 135.8 мян.тонноор, цемент 146.6 мян.тонноор, модон эдлэл 15034.3 мян.төгрөгөөр, дээл 75 ширхэгээр, жижиг оёдол 6265.6 мян.төгрөгөөр тус тус илүү үйлдвэрлэгджээ.

Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт

4.1 Байгаль орчин

Цаг уур

2018 оны 05 дугаар сарын дундаж агаарын температур Улаанбадрах, Хатанбулаг сумдад 20.0-20.3 хэм дулаан, Мандах, Дэлгэрэх сумдад 16.3-16.5 хэм дулаан, бусад сумдын нутгаар 17.4-19.2 хэм дулаан, агаарын хамгийн их температур өдөртөө Хөвсгөл, Хатанбулаг, Замын-Үүд сумдад 36-37 хэм, бусад сумдын нутгаар 31-34 хэм дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж / ОЖД /-тай харьцуулахад: Нийт сумдын нутгаар ОЖД-аас дулаан байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө 0-5 хэм хүйтэн, өдөртөө нийт нутгаар 55-61 хэм дулаан байв.

05 дугаар сард нийт сумдын нутгаар 1-5 өдөр хур тунадастай байж, 0.8-22.7 мм хур тунадас орлоо.

Энэ сард салхины хамгийн их хурд Сайншанд, Замын-Үүд сумдад 25-26 м/с, Мандах, Дэлгэрэх, Эрдэнэ сумдад 22-23 м/с, Хөвсгөл суманд 19 м/с хүрч аюултай болон онц аюултай үзэгдлийн хэмжээнд хүрсэн бол бусад сумдын нутгаар секундэд 7-11 м/с хүрсэн байна. 10м/с-ээс дээш салхитай хоногийн тоо Сайншанд, Замын-Үүд, Мандах, Хөвсгөл, Дэлгэрэх сумдад 19-26, бусад сумдын нутгаар 7-13 өдөр байлаа.

АГУУЛГА

II.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдлын тухай статистикийн тоон мэдээлэл
(Эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар)

Нэг. Эрүүл мэнд
1.1 Эрүүл мэнд
1.2 Төрөлт, эх хүүхдийн эндэгдэл, сумаар
1.3 Халдварт өвчний гаргалт, сумаар
Хоёр.Хөдөлмөр эрхлэлт
2.1 Ажилгүй иргэдийн тоо, боловсролын түвшингээр
2.2 Ажилгүй иргэдийн тоо, сумаар
2.3 Ажлын байрны захиалга, эдийн засгийн салбарын ангилалаар
2.4 Ажлын байрны захиалга ажил мэргэжлийн ангилалаар
2.5. Ажилд зуучилсан иргэд, ажил мэргэжлийн ангилалаар
2.6. Шинэ ажлын байранд орсон иргэн, эдийн засгийн салбарын ангиллаар
Гурав. Нийгмийн даатгал,халамж
3.1 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, төрлөөр
3.2 Нийгмийн даатгалд заавал даатгуулагчийн тоо, олгосон тэтгэврийн хэмжээ
3.3 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо,
олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ
Дөрөв. Гэмт хэрэг
4.1 Бүртгэгдсэн хэргийн тоо төрлөөр, аймгийн дүнгээр
4.2 Бүртгэгдсэн хэргийн тоо сумаар
Тав. Мөнгө, зээл
5.1 Мөнгөн гүйлгээ, зээл
5.2 Хадгаламж, зээл, сумаар, сарын эцэст
Зургаа . Орон нутгийн төсөв
6.1 Орон нутгийн төсвийн орлого, сая төгрөгөөр
6.2 Орон нутгийн төсвийн зарлага, сая төгрөгөөр
6.3 Орон нутгийн төсвийн орлого, зарлага, сумдаар, сая төгрөгөөр
6.4. Улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлсэн орлого, сая төгрөгөөр
Долоо. Үнэ
7.1 Хэрэглээний үнийн индекс
7.2 Хэрэглээний бараа , үйлчилгээний үнэ тариф
7.3 Гол нэрийн барааны үнэ, хөрш зэргэлдээ аймгуудаар
Найм.Хөдөө аж ахуй
8.1 Мал төллөлт, төл бойжилт
8.2 Том малын зүй бус хорогдол
8.3 ХАА-н бүтээгдэхүүний үнийн судалгаа, төрлөөр
8.4 Малын үнийн судалгаа, сумаар
Ес.Аж үйлдвэр
9.1 Нийт бүтээгдэхүүн, борлуулалт, оны үнээр
9.2 Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн жигд ажиллагаа
9.3 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэд салбараар
9.4 Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сумаар, нийт бүтээгдэхүүн гол нэр төрлөөр
Арав. Байгаль орчин
10.1 Цаг уурын үзүүлэлт

Тэмдэглэлийн тайлбар :

(,,,) - тухайн тоо, баримт байхгүй
(0) - тайлант хугацаанд гүйцэтгэлгүй
(x) - энэ хүснэгтэнд тоо нөхөгдөхгүй
(.) - мэдээлэгдэх хугацаа болоогүй

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ
(2018 ОНЫ 05 ДУГААР САРЫН БАЙДЛААР)

I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018	2018 - 2017	2018 2017
							хувь
1. Бэлэн хүн ам	мянган хүн	63.1	66.6	68.2	68.5	0.3	100.4
- Төрсөн хүүхдийн тоо*	тоо	645	612	523	565	42	108.0
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	122	144	147	160	13	108.8
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	523	468	376	405	29	107.7
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	10	9	5	8	3	160.0
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	8.4	14.7	9.6	14.2	4.6	148.1
2. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	411	1294	447	306	-141	68.5
- 10000 хүнд ногдох	тоо	17.9	54	66	45	-21	68.5
3. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 433	1 058	1 650	860	- 790	52.1
- Үүнээс эмэгтэй	тоо	812	557	704	408	- 296	58.0
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	36	25	38	20	- 18	52.1
4. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	241	145	121	92	-29	76.0
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	241	122	121	65	-56	53.7
Улирлын чанартай ажлын байр	тоо	0	23	0	27	27	
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	243	272	276	251	-25	90.9
- 10000 хүнд ногдох ***	тоо	57	64	64	58	-6	90.4
6.Бойжиж буй төл, мян толгой	толгой	495055	441386	518330	540011.0	21681	104
- Унага	толгой	14239	8544	11900	12312.0	412	103
- Тугал	толгой	13384	8909	9640	11291.0	1651	117
- Ботго	толгой	5227	5268	5714	5834.0	120	102
- Хурга	толгой	237702	225379	264407	274539.0	10132	104
- Ишиг	толгой	224503	193286	226669	236035.0	9366	104
7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	5334.9	7462.9	35308.0	79542.4	44234.4	2.3²
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	4820.4	4890.1	69985.6	112477.0	42491.4	160.7

* - 2015, 2016, 2017 оны жилийн эцэст
**-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.
*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.

II.ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 05 сарын эцэст

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-V	2018 I-V	Өсөлт	
		тоо			хувь
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	153.0	154.0	1.0	100.7
2. Ор хоног	мян.хүн	51.9	54.6	2.7	105.2
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	4.9	4.6	-0.3	93.9
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	7.2	7.6	0.4	105.6
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	8.2	8.7	0.5	106.1
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	1.4	1.5	0.1	107.1
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	1132	1299	167	114.8
Үүнээс: нас баралт	хүн	36	32	-4	88.9
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	664	665	1	100.2
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	580	575	-5	99.1
8. Амаржсан эх	хүн	518	563	45	108.7
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	0	1	1	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	5	8	3	160.0

1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн эхний 05 сарын эцэст

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насанда эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
	тоо				
Дүн	563	0	565	8	1
Айраг					
Алтанширээ					
Даланжаргалан					
Дэлгэрэх					
Иххэт	1		1		
Мандах					
Өргөн					
Сайхандулаан					
Улаанбадрах				1	
Хатанбулаг	1		1		
Хөвсгөл	0				
Эрдэнэ	2		2	1	
Сайншанд	452		453	4	
Замын - Үүд	107		108	2	1

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар

1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн эхний 05 сарын эцэст

Үзүүлэлт	2017 I-V	2017 I-V	Өсөлт	
	тоо			хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	447	306	-141	68.5
Вируст гепатит	6	2	-4	33.3
Сүрьеэ	41	40	-1	97.6
Тэмбүү	57	43	-14	75.4
Заг хүйтэн	62	89	27	143.5
Трихомониаз	45	36	-9	80.0
Цусан суулга	11	13	2	118.2
Бусад	225	83	-142	36.9

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар

2.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 05 сарын эцэст

Боловсролын түвшингээр	2015 V	2016 V	2017 V	2018. V	2018. V / 2015. V	2018. V / 2017.V
	хүний тоо				хувь	
ДҮН	1 433	1 058	1 650	860	60.0	52.1
Үүнээс: Эмэгтэй	812	557	804	408	50.2	50.7
Магистр, доктор	4	7	7	1	25.0	14.3
Дээд боловсролтой	396	253	385	168	42.4	43.6
Тусгай дунд	170	129	148	43	25.3	29.1
Техник мэргэжлийн	122	126	138	55	45.1	39.9
Бүрэн дунд	478	366	763	515	107.7	67.5
Бүрэн бус дунд	205	142	157	52	25.4	33.1
Бага	45	29	29	6	13.3	20.7
Боловсролгүй	13	6	23	20	153.8	2.2²

2.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 05 сарын эцэст

	Ажилгүй иргэдийн тоо		Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн хүний тоо	
	2017. V	2018. V	2017. V	2018.V	2017.V	2018.V
ДҮН	1650	860	166	133	374	1074
Айраг	200	20	30	14	32	62
Алтанширээ	22	29	4	7	10	56
Даланжаргалан	63	38	5	6	10	40
Дэлгэрэх	47	22	12	3	22	12
Иххэт	41	39	0	18	3	54
Мандах	86	23	4	16	0	43
Өргөн	55	25	21	13	54	37
Сайхандулаан	51	13	4	1	12	17
Улаанбадрах	12	21	3	16	1	47
Хатанбулаг	29	19	4	0	8	32
Хөвсгөл	29	7	15	7	16	17
Эрдэнэ	20	21	4	2	13	30
Сайншанд	725	445	30	21	157	454
Замын - Үүд	270	138	30	9	36	173

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, 05 сарын эцэст

Салбарын ангилал	2017.V	2018.V
	тоо	
Бүгд	270	204
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	9	2
Уул уурхай олборлох аж үйлдвэр	117	109
Боловсруулах үйлдвэрлэл	4	
Цахилгаан, хий, уур, агааржуулалт		1
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа		5
Барилга	1	1
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ		1
Тээвэр агуулахын үйл ажиллагаа		8
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ		
Мэдээлэл, холбоо	1	
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	3	6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа		
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа		
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа		2
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	39	19
Боловсрол	21	10
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	14	14
Урлаг, үзвэр,тоглоом наадам	7	7
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	54	19
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа,өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн нэр төрлөөр нь салгаж тодорхойдох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ		
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа		

2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, 05 сарын эцэст

Үзүүлэлт	2017. 5V	2018. V
	тоо	
Бүгд	270	204
Менежер	10	1
Мэргэжилтэн	78	53
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	31	26
Контор, үйлчилгээний ажилтан	11	11
Худалдаа, үйлчилгээний ажилтан	39	13
ХАА, ой загас агнуурын ажилтан	1	2
Үйлдвэрлэл, барилга,гар урлал,холбогдох ажил үйлчилгээний ажилтан	25	17
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	44	28
Энгийн ажил мэргэжил	28	44
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	3	9

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

2.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангилалаар 05 сарын эцэст

Үзүүлэлт	2017. V		2018. V	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	тоо		тоо	
Бүгд	166	83	133	60
Менежер	9	2	2	2
Мэргэжилтэн	26	21	22	16
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	17	13	13	10
Контор, үйлчилгээний ажилтан	8	7	9	6
Худалдаа, үйлчилгээний ажилтан	29	19	13	8
ХАА, ой загас агнуурын ажилтан	1	0		
Үйлдвэрлэл, барилга,гар урлал,холбогдох ажил үйлчилгээний ажилтан	11	2	10	3
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	35	6	16	5
Энгийн ажил мэргэжил	28	12	39	6
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	2	1	9	4

2.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 05 сарын эцэст

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс:Ажлын байрны шинж, чанараар	
			Байнга	Улирал
	тоо			
Бүгд	92	28	65	27
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1		1	
Уул уурхай олборлолт	39	12	20	19
Боловсруулах үйлдвэрлэл				
Цахилгаан,хий уур агааржуулалтын хангамж				
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент				
Барилга	39	8	31	8
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	6	5	6	
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	1		1	
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа				
Мэдээлэл холбоо				
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа				
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа				
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа				
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	3		3	
Боловсрол	1	1	1	
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	2	2	2	
Урлаг үзвэр тоглоом наадам				
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа				
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа				

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА төрлөөр, жил бүрийн 05 сарын эцэст

Үзүүлэлт	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2018 I-V / 2017 I-V
	2017 I-V	2018 I-V	
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	10 861.0	13 009.5	119.8
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	6 588.7	8 175.9	124.1
Тэтгэмжийн даатгалын сангийн	745.7	925.5	124.1
Эрүүл мэндийн даатгалын сангийн	2 144.2	2 186.4	102.0
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	1 084.8	1 349.5	124.4
Ажилгүйдлийн даатгалын сангийн	297.6	372.2	125.1
Нийгмийн даатгалын сангийн зарлага	15625.8	17953.0	114.9
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	11 350.3	13 162.5	116.0
Тэтгэмжийн даатгалын сангийн	828.5	1 041.4	125.7
Эрүүл мэндийн даатгалын сангийн	2 418.4	2 699.7	111.6
ҮОМШӨ**-ний даатгалын сангийн	600.3	729.6	121.5
Ажилгүйдлийн даатгалын сангийн	428.3	319.8	74.7

**- ҮОМШӨ- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧДЫН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 05 сарын эцэст

Үзүүлэлт	хэмжих нэгж	2017 I-V	2018 I-V	2018 I-V / 2017 I-V
1. Заавал даатгуулагч хүний тоо	тоо	14176	15175	107.0
Үүнээс: Аж ахуй нэгж, байгууллага	тоо	6683	7633	114.2
Төсөвт байгууллага	тоо	7493	7542	100.7
2. Олгосон тэтгэвэр	сая төгрөг	11669.4	13513.0	115.8
Үүнээс: Өндөр насны тэтгэвэр	сая төгрөг	8595.4	9871.6	114.8
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн тэтгэвэр	сая төгрөг	1258.1	1516.3	120.5
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	сая төгрөг	589.6	666.3	113.0
ҮОМШӨ-ний даатгалын сангийн тэтгэвэр	сая төгрөг	339.1	363.3	107.1
Цэргийн тэтгэвэр	сая төгрөг	887.2	1095.5	123.5

Эх үүсвэр: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс

3.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 05 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2018 I- V 2017I-V	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2018 I- V 2017 I- V
	2017 I-V	2018 I-V		2017 I- V	2018 I-V	
	тоо		хувь	мянган төгрөг		хувь
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ	**15869**	**19940**	**125.7**	**2457052.6**	**3339104.4**	**135.9**
1. Халамжийн тэтгэвэр	**1275**	**1306**	**102.4**	**564340.1**	**934442.4**	**165.6**
Ахмад настны тэтгэвэр	52	56	107.7	23511.0	39766.2	169.1
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	1223	1250	102.2	540829.1	894676.2	165.4
2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж	**1077**	**1020**	**94.7**	**295155.1**	**316207.6**	**107.1**
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэнд олгосон тэтгэмж	1000	960	96.0	274929.2	296777.1	107.9
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	51	48	94.1	14858.7	16463.6	110.8
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	6	6	100.0	1320.5	1714.0	129.8
Ахмад настаныг гэртээ асрамжилж байгаа иргэн	11	5	45.5	2901.1	1188.9	41.0
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн	9	1	11.1	1145.6	64.0	5.6
3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн	**998**	**893**	**89.5**	**330190.0**	**226710.5**	68.7
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	362	226	62.4	193928.4	158990.5	82.0
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	595	646	108.6	127061.6	42960.0	33.8
Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/	37	4	10.8	3600.0	360.0	10.0
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	1	5	5.0²	2000.0	10000.0	5.0²
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	2	4	2.0²	2400.0	4800.0	5.0²
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	1	5	5.0²	1200.0	6000.0	2.0²
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр орондгүй иргэн		3			3600.0	
4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал						
5. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зардал	**5784**	**6135**	**106.1**	**455220.7**	**296573.1**	**65.1**
Ахмад настанд үзүүлсэн тусламж,хөнгөлөлтийн зарцуулалт	3677	3381	91.9	162806.8	76964.3	47.3
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	159	154	96.9	27705.6	21803.1	78.7
Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн, сум, хорооны нийгмийн ажилтанд олгох урамшил					2693.1	
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт		1596	0.0		92928.4	
